



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/242

Сүхбаатар сум

Г

Хөрөнгө гаргах тухай

Г


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.1, 32.1.3, 32.1.10, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 4.3, 6.5 заалт, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 66 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалын нөөцийг бүрдүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Бараа материалын нөөцийг худалдан авахад шаардлагатай 91,520,000.00 /ерэн нэгэн сая таван зуун хорин мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.


3.Бараа материалын нөөцийг бүрдүүлж, зарцуулалтын тайланг 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор гаргаж, аймгийн Засаг даргын тамгын газарт ирүүлэхийг Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Г.Галбадрах/-д даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.



430810579

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2021 оны 08 сарын 28 -ны өдрийн
А/242 тоот захирамжийн хавсралт



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС ХАМГААЛАХ
БАРАА МАТЕРИАЛЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	N95 амны хаалт	ш	5000	2,800	14,000,000
2	Гарын шингэн саван	ш	150	3,500	525,000
3	Санитол гипон 5л	ш	30	60,000	1,800,000
4	Нойтон салфетка	боод	500	3,100	1,550,000
5	Хуурай салфетка	боод	500	1,200	600,000
6	Нүүрний хаалт	ш	3000	1,400	4,200,000
7	Нэг удаагийн халдвар хамгааллын хувцас	ш	3000	15,500	46,500,000
8	Санитас 1л	ш	500	16,000	8,000,000
9	Улавч	ш	1300	250	325,000
10	Спирт	л	200	1,100	220,000
11	Нэг удаагийн бээлий	хайрцаг	200	39,000	7,800,000
12	Нэг удаагийн амны хаалт	ш	30000	200	6,000,000
	Нийт дүн				91,520,000

Хянасан:

АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хөрөнгө оруулалт
хариуцсан нягтлан бодогч

Ч.Сугардорж

Төсөв боловсруулсан:

Онцгой байдлын газрын нягтлан
бодогч, ахмад

Ц.Батчимэг